

БАТЛАВ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Д. ГАНХУЯГ

2023 оны 07 дугаар сарын 10-ны өдөр

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ 2023 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын шалтгаан нөхцөлийг арилгах, таслан зогсооход чиглэсэн арга хэмжээ авах, төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг арилгахад оршино.


Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
1.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх.	1.1. АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх.	-Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх.
		1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах.	-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.
		1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах.	-Мэдээллийг сар бүр шинэчлэх; -Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.
		1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.	-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх.

2.	Авлигын эсрэг сургалт байгуулах, сургалтад хамруулах.	2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх.	-Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.
		2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.	-Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.
3.	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох.	3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх.	-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах; -Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.
		3.2.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх.	-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; -Сургалт, мэдээлэл авсан байх; -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх.
4.	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах.	4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м)	-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.
		4.2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх.	-2-оос доошгүйг зохион байгуулсан байх; -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.

		4.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	-Бодитой үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.
5.	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх.	5.1.Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах.	-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.
		5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал.	-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.
		5.3.Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах.	-Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; -khutulbur.iaас.mn цахим санд нэмж оруулсан байх; -Тайлагнасан байх.
		5.4.Харьяа байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудыг сургагч багшаар бэлтгэх.	-Сургагч багшаар бэлтгэгдсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.
		5.5.Байгууллага, аж ахуй нэгж бүр "Авлигын эсрэг 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г баталж хэрэгжүүлэх, төлөвлөгөөний үр дүнг тооцох.	-Төлөвлөгөөг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх; -Тайлагнасан байх.
		5.6.Тухайн байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчид холбогдуулан иргэн, албан тушаалтнаас ирүүлсэн өргөдөл, гомдол, түүний бүртгэл, шийдвэрлэлттэй танилцах.	-Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлттэй танилцах; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН




Л.ГАНЗОРИГ

ХЯНАСАН:

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА,

ЯАМНЫ ХУУЛИЙН ЗӨВЛӨХ




Г.ЭНХБОЛД

ТАНИЛЦСАН:

СТРАТЕГИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН

ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА



Ч.ГАНДИРВАА